



## ТӨВ АЙМГИЙН ЗУУНМОД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ

### 2014 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ТАБ-ын Дарга, тэргүүлэх аудитор

Л.Жаргалсайхан

И-мейл: [jargalsaihan\\_tuv@yahoo.com](mailto:jargalsaihan_tuv@yahoo.com)

Утас: 70272582

Факс: 01-272-22582

### Аудитын тайлан

Хавсралт 1: Агуулга  
Хавсралт 2: Аудитын гэрчилгээ  
Хавсралт 3: Менежментийн захидал  
Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан  
Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Аудитын менежер:

О.Амаржаргал

И-мейл: [amaraa\\_tuv@yahoo.com](mailto:amaraa_tuv@yahoo.com)

Утас: 70273465

Аудитор      О.Сосор

Утас: 70273204    97020991

И-мейл: [Sosor009@yahoo.com](mailto:Sosor009@yahoo.com)

Аймгийн аудитын газрын хаяг:

Төв аймаг Зуунмод сум 1-р баг

Төрийн байгууллагуудын ордон

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

2015 оны 3 дугаар сар

## **АГУУЛГА**

---

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
8. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохиорох загварын талаарх дүгнэлт

### **Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:**

Төсвийн тухай хуулийн 8.9.3, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дүгээр зүйлд заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Төв аймгийн Зуунmod сумын ИТХурлын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд / ТӨВ-2015/84/СТА-ТТЗ / аудит хийллээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Төв аймгийн Зуунmod сумын ИТХурлын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төв аймгийн Зуунmod сумын ИТХурлын 2014 оны төсвийн санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 25-наас 2015 оны 03 дүгээр сарын 26 ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитын багийн гишүүн аудитор О.Сосор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Төв аймгийн Зуунmod сумын ИТХурлын 2014 оны төсвийн санхүүгийн тайланг 2015 оны 03 дугаар сарын 25-нд ТАБ-т ирүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага аудитыг 2015 оны 03 дүгээр сарын 29-нөөс 2015 оны 03 дүгээр сарын 31-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2015 оны 04 дугаар сарын 10-нд Зуунmod сумын ИТХурлын удирдлагад гардуулна.

### **Байгууллагын хууль, эрх зүйн орчин:**

Төсвийн захирагч нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд ЗГ-ын 2005 оны 233 дугаар тогтоолоор батлагдсан “Үндсэн хөрөнгөд элэгдэл тооцох тухай” журмыг 2014 оны 297 дугаар тогтоолоор хүчингүй болгосон байна.

### **Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18.1.”Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьялануулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж бие даан шийдвэрлэх эрхтэй бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой Зуунmod эрхэд хадгалж хэрэгжүүлнэ” гэж энэ байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хуулийн 16 дүгээр зүйлийн 1-д “Аймаг, нийслэл, сум, дүүргийн Хурал төсөвтэй байх бөгөөд түүнийг Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрийг үндэслэн Хурлын нарийн бичгийн дарга захирсан зарцуулна.:” Төсвийн тухай хуулийн 16.4.14. “аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төсвийн шууд захирагч байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.38-д “төсвийн шууд захирагч” гэж төсвийн ерөнхийлөн захирагч болон төсвийн төвлөрүүлэн захирагчаас хуваарилсан чиг үргийн төсвийг төлөвлөх, хууль тогтоомжийн дагуу захиран зарцуулах, гүйцэтгэлийг тайлагнах эрх бүхий этгээдийг” гэж заасны дагуу Төв аймгийн Зуунmod сумын ИТХурлын нарийн бичгийн дарга Төсвийн шууд захирагчийн үргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сум, аймгийн ИТХурлаас баталж Аймгийн төрийн сангаас олгож байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэр, түүний удирдлагын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиуд Зуунmod хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төв аймгийн Зуунmod сумын ИТХурлын төсвийн 2014 оны санхүүгийн тайланда дүгнэлт өгөх үүднээс Төв аймгийн Зуунmod сумын ИТХурлын удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын болон нарийвчилсан 5 горим сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь байгууллагын даргын тушаалаар баталж албажаагүй байна. Бүртгэлийн acolous програм ашигладаг байна.

Төсвийн шууд захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төв аймгийн Зуунmod сумын ИТХурлын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайлан гаргасан байна.

**Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланда материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн программаар боловсруулж байна. Эдгээр журам нь УСНББОУС-тай нийцсэн байна.

**Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төв аймгийн Зуунмод сумын ИТХурлын Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн шууд захирагч нь 2014 онд орон нутгийн төсвөөс батлагдсан төлөвлөгөөний дагуу урсгал зардалд 74089,0 мянган төгрөгийн санхүүжилт авахаас, Азийн хөгжлийн сангаас 30527.9 мянган төгрөг, 104616,9 нийт мянган төгрөгийн санхүүжилт авсан байна. Гүйцэтгэлээр урсгал зардалд 101592,4 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 3024,5 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

#### **Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдэлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд мөнгө хөрөнгө, бараа материал, орлого, зардлын данс бүрээр хяналтын ба нарийвчилсан 5 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Эдгээр эрсдэлүүд нь төсвийг хэмнэлтгүй зарцуулсан, төсвийг үр ашиггүй зарцуулсан, төсвийн зориулалтыг зөрчсөн, хөрөнгийн хадгалалт хамгаалалтыг сулруулж цаашид хөрөнгийг үрэгдүүлэх, чанар байдлыг алдагдуулах, байгууллагын үйл ажиллагааны цар хүрээг бууруулсан, хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй зөрчдөг зэрэг муу үр дагаварт хүрч болзошгүй байна

#### **Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Төв аймгийн Зуунмод сумын ИТХурлын төсвийн 2014 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, мөнгөн хөрөнгийн 50,0 мянган төгрөгөөс дээших ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгахад нийт зардлын 97.7 хувийг хамруулсан.. /ТАБ-СТА-В-3/

#### **Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг**

##### **Шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Харилцах данснаас 2781.6 мянган төгрөгийг шууд зардлын дансанд бичсэн зөрчил илэрсэн

Шийдвэрлэсэн нь Сангийн сайдын 388-р тушаалаар батлагдсан Нягтлан бodoх бүртгэлийн дансны зааврыг мөрдөж ажиллах зөвлөмж бичсэн.

#### **Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад залруулсан алдаа байхгүй болно.

#### **Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Тухайн аудитын хамрах хүрээний асуудал боловч аудитын хугацааны шалтгаанаас аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох төсвийн зарцуулалтыг завсрлын аудитаар шалгахаар тогтоов.

#### **Санхүүгийн тайланда хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Төв аймгийн Зуунмод сумын ИТХурлын төсвийн 2014 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалингийн хүснэгтэнд гарын үсэг бүрэн зурагдаагүй зөрчил илэрсэнд зөвлөмж бичигдсэн.

**Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төв аймгийн Аудитын газар нь сумын ИТХурал, ЗДТГазар, Баг буюу НЕҮ-ний санхүүгийн тайланда аудит хийсэн дүгнэлт тайлан, удирдлагын захидал, гэрчилгээг сумын Засаг даргад хүргүүлдэг байсан. Иймд Зуунмод сумын ИТХурлын төсвийн 2013 оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй.

**Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:**

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Төв аймгийн Зуунмод сумын ИТХурлын төсвийн 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 6 хуудсыг тус тус хавсаргав.

**АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:**

**ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР**

**Л.ЖАРГАЛСАЙХАН**

**АУДИТЫН МЕНЕЖЕР**

**О.АМАРЖАРГАЛ**

**БЭЛТГЭСЭН: АУДИТОР**

**О.СОСОР**

**2015 оны 04 сарын 10**